



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 541

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж,
данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам"-ын 6.2.1, 6.2.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Завхан аймгийн Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2018 оны 07-07-027/155 дугаар дүгнэлтээр цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 1,014,000.00 (нэг сая арван дөрвөн мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Улсын Ерөнхий Прокурорын газрын Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Тамгын газрын дарга Ц.Арвинбуудай, Завхан аймгийн Прокурорын газрын Ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Н.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Газар дээрх барилга байгууламжийг буулгах, хог хаягдлыг цэвэрлэх, газрыг нөхөн сэргээх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;


2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ГАВАА



0002561

Төсөл

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 2 дугаар сарын 11-ны өдрийн
БАН дугаар тогтоолын хавсралт

ЗАВХАН АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл үнэ
1	Зуны амралтын байшин	2003	ш	1	1,014,000.00	1,014,000.00	-
НИЙТ ДҮН					1,014,000.00 (нэг сая арван дөрвөн мянган)	1,014,000.00 (нэг сая арван дөрвөн мянган)	-